

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан
Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн
найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсэг:

“58.5.Зохигчид шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлнө.”

2/59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэг:

“59.7 Энэ хуулийн 74^{1.5}-т заасны дагуу талууд эвлэрсэн, эсхүл 74^{1.6}-т заасны дагуу зохигчид эвлэрсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7^{1.1} дэх хэсгийн “30 000 төгрөгийн” гэснийг “40 800 төгрөгийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг